



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 21

Номгон

Г Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн  
аймгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн аймгийн салбар зөвлөлийн журамд заасан нийтлэг үүргийн дагуу “Хос бичигтэн” аймгийн дэд хөтөлбөртэй уялдуулан төлөвлөгөө гаргаж, төрийн бүх шатны байгууллагын удирдлагуудад Монгол хэлний тухай хуулийг сурталчлах, байгууллагын ажилтнуудад танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Үндэсний бичгийн сургалтын болон хэрэглээний орчинг сайжруулж, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Гурванбулаг, Баян-Өндөр, Хүрээмарал сумдын сургуульд үндэсний бичгийн танхим байгуулан, зарим сумдын сургууль, анги танхимиын хаягыг шинэчилэн, сургалтын хэрэглэгдэхүүнээр баяжилт хийсэн, цахим орчинд үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэхээр 146 төрийн албан хаагчийн комьюнитерт үндэсний бичгийн програм суулган ашиглаж байна. Монгол хэл, бичиг үсгээ судлах, өвлөх, хэрэглэх талаар санаачилга гарган ажиллаж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг дэмжин хамтран ажилласан нь үр дүнтэй байгаа бөгөөд Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн аймгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, үйл ажиллагааг тогтмолжуулах, өрөө танхимтай болгох зэрэг ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байгааг тэмдэглээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйл, Монгол хэлний тухай хуулийн 17 зүйл, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай.

Салбар зөвлөлийн дарга: Г.Батжаргал-Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Б.Одгэрэл-Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн

Гишүүд: Б.Бямбачимэг-Номундалай ахлах сургуулийн Монгол хэл, бичиг уран зохиолын багш

Л.Отгонбаяр-Эрдэм ахлах сургуулийн Монгол хэл, бичиг уран зохиолын багш

Б.Даваадорж-Эрдэнэмандал ахлах сургуулийн Монгол хэл, бичиг уран зохиолын багш

Ж.Энхбаяр-Аймгийн Ахмадын хорооны дарга

С.Үнэнбуян-Аймгийн Эрчүүдийн холбооны нарийн бичгийн дарга

Ж.Одончимэг-Номгон ахлах сургуулийн багш

Д.Бадамгарав-Соого сейко сургуулийн багш

2. Монгол хэлний хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журмыг хэрэгжүүлж, зөвлөлийг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг зөвлөлийн дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн Иргэдийн төлөөлөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 119 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

